БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2026/034/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Ш.Нурлан<br>Утас:99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................................
  3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....................................................................
  3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....................................................................
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.............................................................
  3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан ...................................................................................................................
  4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
  4.2 Материаллаг байдал .............................................................................................................
  4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.............................................................................
  4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....................................
  4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................
  4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..............................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..................................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026-02-16 № 88

танай ____________ -ны № ____________ -т

НОГООННУУР СУМЫН ЦАГААННУУР ТОСГОНЫ ЗАХИРАГЧ А.АРЫСТАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн тооллого хийхдээ 170.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 17.3 сая төгрөгийн бараа материал нийт 192.6 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аймгийн Засаг даргын 2018 оны А/845 дугаар захирамжаар баталсан орон тооноос үндсэн 1, гэрээт 3 орон тоо илүү ажиллуулж төсвөөс 50.1 сая төгрөгийн зардал гаргасан, өмнөх аудитаар бүтэц орон тоог мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол

асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,137,853.90** | **17,331,899.90** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 7,137,853.90 | 17,331,899.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,137,853.90 | 17,331,899.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 35,000.00 | |
| 35420 | Аж ахуйн материал | 2,816,800.00 | 15,000,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,394,154.00 | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,891,899.90 | 2,331,899.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **479,130,033.15** | **591,597,831.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 479,130,033.15 | 591,597,831.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 471,702,254.48 | 584,466,377.01 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 425,441,852.45 | 425,441,852.45 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (93,646,204.58) | (118,873,449.22) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 91,089,999.00 | 171,089,999.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (73,239,999.00) | (83,673,332.32) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 73,330,517.00 | 73,330,517.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (40,959,196.13) | (50,112,763.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,461,659.00 | 30,461,659.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,962,908.90) | (14,480,408.94) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 762,724,341.34 | 852,728,341.34 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (691,567,805.70) | (701,476,037.77) |
| 39217 | Ном | 30,000.00 | 30,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,427,778.67 | 7,131,454.75 |
| 39301 | Програм хангамж | 3,874,639.00 | 3,874,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,693,260.33) | (1,989,584.25) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,246,400.00 | 5,246,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **486,267,887.05** | **608,929,731.66** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,377,683.00** | **6,821,400.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,377,683.00 | 6,821,400.00 |
| **413** | **Өглөг** | 5,377,683.00 | 6,821,400.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,377,683.00 | |
| **4136** | **Бусад өглөг** | - | 6,821,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 6,821,400.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **480,890,204.05** | **602,108,331.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 480,890,204.05 | 602,108,331.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 876,594,219.00 | 876,594,219.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 876,594,219.00 | 876,594,219.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (687,024,748.47) | (565,806,620.86) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (687,024,748.47) | (687,024,748.47) |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 121,218,127.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 291,320,733.52 | 291,320,733.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **486,267,887.05** | **608,929,731.66** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **690,688,415.00** | **862,755,598.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **117,624,450.00** | **192,674,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 117,624,450.00 | 169,674,600.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,430,000.00 | 7,670,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,430,000.00 | 7,670,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 106,194,450.00 | 147,004,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 9,000,000.00 | 15,000,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 23,000,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 23,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **573,063,965.00** | **670,080,998.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,909,840.00 | 794,511.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,909,840.00 | 794,511.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 570,154,125.00 | 669,286,487.50 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 570,154,125.00 | 669,286,487.50 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **622,692,339.22** | **741,537,470.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **622,692,339.22** | **741,537,470.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 609,074,979.22 | 710,146,398.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 431,009,398.00 | 498,327,346.31 |
| 210101 | Үндсэн цалин | 199,355,994.78 | 229,526,150.54 |
| 210102 | Нэмэгдэл | 141,765,151.22 | 170,154,565.10 |
| 210104 | Урамшуулал | 6,855,300.00 | 22,330,213.69 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 83,032,952.00 | 76,316,416.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,339,900.00 | 65,110,585.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,719,000.00 | 45,569,085.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,405,200.00 | 5,089,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,202,600.00 | 2,545,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,202,600.00 | 2,545,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,810,500.00 | 9,361,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,649,563.00 | 39,333,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,215,063.00 | 5,150,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,100,900.00 | 33,183,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 333,600.00 | 999,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,182,740.00 | 24,257,604.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,026,400.00 | 2,103,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,899,440.00 | 20,691,204.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 955,900.00 | 929,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 301,000.00 | 534,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,078,857.00 | 1,490,002.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,078,857.00 | 1,490,002.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,993,780.00 | 5,371,408.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 619,400.00 | 123,600.00 |
| 210602 | Тавилга | 8,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,365,880.00 | 5,247,808.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,460,000.00 | 2,350,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,460,000.00 | 2,350,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 739,100.00 | 1,294,252.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 206,100.00 | 472,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 125,552.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 77,000.00 | 61,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 21,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 435,000.00 | 634,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 74,621,641.22 | 72,612,001.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,736,500.00 | 14,975,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 260,000.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,625,141.22 | 57,536,201.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,617,360.00 | 31,391,072.19 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,617,360.00 | 8,318,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,817,360.00 | 8,118,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 23,073,072.19 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 23,073,072.19 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **67,996,075.78** | **121,218,127.61** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **67,996,075.78** | **121,218,127.61** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **575,493,965.00** | **677,751,598.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,430,000.00** | **7,670,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,430,000.00 | 7,670,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,430,000.00 | 7,670,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,430,000.00 | 7,670,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **573,063,965.00** | **670,080,998.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 0.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,909,840.00 | 794,511.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,909,840.00 | 794,511.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 570,154,125.00 | 669,286,487.50 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 570,154,125.00 | 669,286,487.50 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **565,863,965.00** | **677,751,598.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **565,863,965.00** | **677,751,598.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **552,246,605.00** | **646,360,526.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 426,806,165.00 | 503,705,029.31 |
| 210101 | Үндсэн цалин | 211,452,761.78 | 234,903,833.54 |
| 210102 | Нэмэгдэл | 161,765,151.22 | 170,154,565.10 |
| 210104 | Урамшуулал | 6,855,300.00 | 22,330,213.69 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 46,732,952.00 | 76,316,416.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,339,900.00 | 65,110,585.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,719,000.00 | 44,750,985.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,405,200.00 | 5,089,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,202,600.00 | 2,545,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,202,600.00 | 2,545,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,810,500.00 | 10,179,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,815,963.00 | 38,097,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,215,063.00 | 5,150,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,100,900.00 | 31,947,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 999,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,096,340.00 | 18,528,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,026,400.00 | 1,353,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,831,690.00 | 14,446,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,887,250.00 | 2,196,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 100,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 351,000.00 | 430,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 700,000.00 | 1,490,002.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 700,000.00 | 1,490,002.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,708,000.00 | 4,266,408.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 743,400.00 | 123,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 130,900.00 | |
| 210604 | Урсгал засвар | 1,833,700.00 | 4,142,808.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,380,000.00 | 2,170,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,380,000.00 | 2,170,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 739,100.00 | 1,734,252.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 206,100.00 | 888,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 109,752.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 77,000.00 | 61,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 21,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 435,000.00 | 674,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,661,137.00 | 11,259,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,401,137.00 | 11,159,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 260,000.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,617,360.00** | **31,391,072.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,617,360.00 | 8,318,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,817,360.00 | 8,118,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.00 | 23,073,072.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 23,073,072.19 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,630,000.00** | **0.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,630,000.00** | **0.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,630,000.00** | **0.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,630,000.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,630,000.00 | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-9,630,000.00** | **0.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **СТ-4А**

/төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 876,594,219.00 | 291,320,733.52 | -761,442,715.07 | | 406,472,237.45 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн | | | 6,421,890.82 | | 6,421,890.82 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **876,594,219.00** | **291,320,733.52** | **-755,020,824.25** | **0.00** | 412,894,128.27 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 67,996,075.78 | | 67,996,075.78 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **291,320,733.52** | **-687,024,748.47** | **0.00** | 480,890,204.05 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **291,320,733.52** | **-687,024,748.47** | **0.00** | 480,890,204.05 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **876,594,219.00** | **291,320,733.52** | **-687,024,748.47** | **0.00** | 480,890,204.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 121,218,127.61 | | 121,218,127.61 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **876,594,219.00** | **291,320,733.52** | **-565,806,620.86** | **0.00** | **602,108,331.66** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **ТГ**

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **668,418,400.00** | **570,154,125.00** | **666,615,500.00** | **646,213,415.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 668,418,400.00 | 570,154,125.00 | 666,615,500.00 | 646,213,415.31 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 654,550,000.00 | 556,536,765.00 | 658,297,500.00 | 637,895,415.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 440,522,600.00 | 426,664,415.00 | 514,988,400.00 | 498,425,163.31 |
| 210101 | Үндсэн цалин | 207,545,300.00 | 211,452,761.78 | 221,229,900.00 | 232,757,707.54 |
| 210102 | Нэмэгдэл | 172,346,300.00 | 161,765,151.22 | 208,601,200.00 | 170,154,565.10 |
| 210104 | Урамшуулал | 14,981,000.00 | 6,855,300.00 | 22,554,900.00 | 22,167,288.69 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 45,650,000.00 | 46,591,202.00 | 62,602,400.00 | 73,345,601.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн** | 50,339,900.00 | 50,339,900.00 | 64,822,300.00 | 64,822,300.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **даатгалд төлөх шимтгэл** | | | | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,719,000.00 | 32,719,000.00 | 44,462,700.00 | 44,462,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,405,200.00 | 4,405,200.00 | 5,089,800.00 | 5,089,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,202,600.00 | 2,202,600.00 | 2,545,100.00 | 2,545,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,202,600.00 | 2,202,600.00 | 2,545,100.00 | 2,545,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,810,500.00 | 8,810,500.00 | 10,179,600.00 | 10,179,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,600,900.00 | 21,600,600.00 | 37,947,200.00 | 37,947,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,000,000.00 | 1,999,700.00 | 5,000,100.00 | 5,000,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,100,900.00 | 19,100,900.00 | 31,947,200.00 | 31,947,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 | 999,900.00 | 999,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,789,800.00 | 20,778,250.00 | 17,915,200.00 | 17,915,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,814,000.00 | 2,026,400.00 | 1,249,500.00 | 1,353,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,064,400.00 | 15,513,600.00 | 14,250,200.00 | 13,893,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,441,400.00 | 2,887,250.00 | 2,257,800.00 | 2,136,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | 100,400.00 | 100,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 470,000.00 | 351,000.00 | 57,300.00 | 430,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 700,000.00 | 700,000.00 | 480,000.00 | 480,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 700,000.00 | 700,000.00 | 480,000.00 | 480,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,186,600.00 | 2,708,000.00 | 3,166,800.00 | 3,142,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 743,400.00 | 743,400.00 | 100.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 143,200.00 | 130,900.00 | | |
| 210604 | Урсгал засвар | 2,300,000.00 | 1,833,700.00 | 3,166,700.00 | 3,142,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,000,000.00 | 3,380,000.00 | 2,170,000.00 | 2,170,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,000,000.00 | 3,380,000.00 | 2,170,000.00 | 2,170,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,959,200.00 | 739,100.00 | 1,734,800.00 | 1,734,252.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 583,500.00 | 206,100.00 | 888,700.00 | 888,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 433,000.00 | | 110,000.00 | 109,752.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,800.00 | 77,000.00 | 61,700.00 | 61,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 392,000.00 | | 200.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,400.00 | 21,000.00 | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 817,000.00 | 435,000.00 | 674,100.00 | 674,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | | 100.00 | 100.00 |
| 210808 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад БОНСэргээх зардал | 300,000.00 | | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 109,451,000.00 | 29,626,500.00 | 15,072,800.00 | 11,259,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,889,000.00 | 29,331,000.00 | 14,972,500.00 | 11,159,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 562,000.00 | 295,500.00 | 100,300.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,868,400.00 | 13,617,360.00 | 8,318,000.00 | 8,318,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,868,400.00 | 13,617,360.00 | 8,318,000.00 | 8,318,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,817,400.00 | 12,817,360.00 | 8,118,000.00 | 8,118,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,051,000.00 | 800,000.00 | 200,000.00 | 200,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **668,418,400.00** | **570,154,125.00** | **666,615,500.00** | **646,213,415.31** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 668,418,400.00 | 570,154,125.00 | 666,615,500.00 | 646,213,415.31 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 664,418,400.00 | 566,154,125.00 | 666,615,500.00 | 646,213,415.31 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 4,000,000.00 | 4,000,000.00 | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.00 | 22.00 | 18.00 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 6.00 | 5.00 | 6.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 | 8.00 | 8.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.00 | 7.00 | 4.00 | 7.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **18.0** | **22.0** | **18.00** | **22.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 5.0 | 4.0 | 5.00 | 4.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8.0 | 10.0 | 8.00 | 10.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.0 | 7.0 | 4.00 | 7.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1.0 | 1.0 | 1.00 | 1.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **ТГ-Н**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,339,840.0** | **8,465,111.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,339,840.0** | **8,465,111.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,339,840.0 | 8,465,111.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 141,750.0 | 5,279,866.0 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,146,126.0 |
| 210104 | Урамшуулал | | 162,925.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 141,750.0 | 2,970,815.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 288,285.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 288,285.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,215,363.0 | 150,000.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,215,363.0 | 150,000.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 318,090.0 | 612,850.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 318,090.0 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 552,850.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 60,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 664,637.0 | 1,010,002.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 664,637.0 | 1,010,002.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,124,108.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 123,600.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | - | 1,000,508.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,000,000.0 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.0 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,339,840.0** | **8,465,111.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,339,840.0 | 8,465,111.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,909,840.0 | 794,511.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,430,000.0 | 7,670,600.0 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 622.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 741.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

Цагааннуур тосгоны захирагчийн албаны нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг тухайн байгууллагад хамааралтай эрсдэлүүдээр шалгаж үзлээ. Тосгоны захирагчийн 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/20 дугаартай захирамжаар түүхт 100 жилийн ойн баярыг тохиолдуулан нутгийн түүхийг таниулан сурталчилах ажлын хүрээнд “Хөх тэнгэрийн эсгий туургатан” ТТБ-д нэвтрүүлэх хийлгэсэний төлбөрт 2.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т ”Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зориулалт бус зардал гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайланг мэдээлээгүй ба шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 98.3 хувьтай, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 93.1 хувьтай байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цагааннуур тосгоны захирагчийн ажлын албаны 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан. 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр байгууллагад очиж үндсэн хөрөнгөөс 26 нэр төрлийн хөрөнгөд тооллого хийсэн ба зөрчил дутагдал гараагүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 5 зөвлөмж өгөгдсөн. Байгууллагын орон тоотой холбоотой зөвлөмжийг  хэрэгжүүлэн ажилаагүй байна. Хэрэгжүүлэн ажилаагүй зөвлөмжийг албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 5 | 162,191.83 | 4 | 115,231.02 | 80.00% |
| Албан шаардлага | 1 | 12,332.80 | 1 | 12,332.80 | 100.00% |
| Актын төлбөр | 1 | 1,281.73 | 1 | 1,281.73 | 100.00% |
| **Нийт дүн** | **7** | 175,806.44 | **6** | 128,845.55 | 85.71% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 881.45 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 25.7 сая төгрөгийн алдааг залруулав. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 2.7 сая төгрөгөөр илүү, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэлээс 23.7 сая төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", УСНББОУС-1 толилуулга стандарттай нийцээгүй байна.

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой 52.5 сая төгрөгийн зөрчил илэрч 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 50.0  сая төгөгийн албан шаардлага өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн зөрчилд[1] төлбөрийн 1 акт тогтоов.

1.Тосгоны захирагчийн 2025 оны Б/05, Б/16 дугаар тушаалаар ажилтнуудад 2025 оны ажлын үр дүнгийн урамшуулал олгоход тосгоны захирагчийг нэмж оруулан 2.5 сая төгрөгний ажлын үр дүнгийн урамшууллыг хууль журам зөрчиж олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 “Төрийн албан хаагчийн цалин хөлс нь”, 28.2.2 “төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс ‚бүрдэнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 50.08 сая төгрөгийн зөрчилд[2] 1 албан шаардлага хүргүүлэв.

1.Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/845 дугаар захирамжаар Захирагчийн албаны орон тоо 18 хүнээр батлагдсан боловч 4 ажилтан илүү ажилуулж эдгээр орон тооны цалингийн зардалд нийт 50.1 сая төгрөгний зардал гаргасан байна. Өмнөх аудитаар Захирагчийн ажлын албаны батлагдсан орон тооны дагуу бүтэц орон тоог батлаж мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Аймгийн Засаг даргын 2018 оны А/845 дугаар захирамжаар батлагдсан орон тооны хязгаарыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Засаг даргын 2018 оны А/845 дугаар захирамжаар батлагдсан орон тооны хязгаарыг баримтлан орон тоог шинэчлэн батлах, илүү орон тооны асуудлыг цэгцэлж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж ажиллах зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 803.0 сая төгрөгийн зөрчил[3] илэрч, 803.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**1. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт*:

Жилийн эцсийн тооллого хийхдээ 170.0 сая төгрөгний үндсэн хөрөнгө, 17.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл нийт 192.6 сая төгрөгний хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2- “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*:

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг бүрэн хийж үлдэгдлийг тулган баталгаажуулах;

**2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

*2.1 Илрүүлэлт:*

Бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 1960 онд ашиглалтанд орсон сайжруулсан шороон зам 594.5 сая төгрөгийн анхны өртөгтэй, үлдэх өртөггүй, хар зам тавигдсан хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", 31.3.3-т "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж*:

Бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 594.5 сая төгрөгийн хөрөнгийг Өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж холбогдох газруудад актлах санал хүргүүлэн, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах;

**3.Анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал**

3.1.Илрүүлэлт:

Тосгоны захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/18 дугаартай захирамжаар өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотой малчдын өвөлжөөнд зам гаргахад зориулан 3.2 сая төгрөг, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/51 дугаартай захирамжаар өвөлжилтийн бэлтэл ажил хангах боодол өвсний нөөц бэтлгэх зорилгоор 3.9 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал данснаас гаргаж Молкен ХХК-аас шатахуун, Травел монголия ХХК-аас өвч худалдан авч бараа материалын тайланд 7.1 сая төгрөгийн орлого авч зарлага гаргасан боловч зарьцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлж бармтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах

үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”,  13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Дээрх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж зөрчлийг арилгах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

**4. Өр төлбөрийн баталгаажуулалттай холбоотой асуудал**

4.1 Илрүүлэлт:

Захирагчийн ажлын алба нь оны эцэст 6.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан боловч үлдэгдлийг харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахаас өмнө өглөгийг харилцагч байгууллага бүрээр н тооцоо нийлж, үлдэгдлийг актаар баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага,зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг буруу гаргасан | 1 | 25,744.0 | | | 1 | 25,744.0 | 1 | 25,744.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **1** | **25,744.0** | | | **1** | **25,744.0** | **1** | **25,744.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин хөлстэй холбоотой | 1 | 2,588.38 | 1 | 2,588.38 | - | - | | | | | | |
| Орон тооны хязгаартай холбоотой | 1 | 50,081.0 | - | - | 1 | 50,081.0 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой | 1 | 594,500.00 | - | - | | | 1 | 594,500.00 | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой | 1 | 7,109.00 | 0 | - | - | - | 1 | 7,109.00 | | | | |
| Өр төлбөр тооцоо нийлсэн акт | 1 | 6,821.40 | | | | | 1 | 6,821.40 | | | | |
| Үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогтой холбоотой | 1 | 192,612.30 | | | | | 1 | 192,612.30 | | | | |
| **Дүн** | **6** | **853,712.08** | **1** | **2,588.38** | **1** | **50,081.0** | **4** | **801,042.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |

| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хуулийн хэрэгжилттэй холбоотой | 1 | 2,000.00 | | | | | 1 | 2,000.00 |
| Дүн | 1 | 2,000.00 | | | | | 1 | 2,000.00 |
| **Нийт дүн** | **1** | **2,000.00** | | | | | **1** | **2,000.00** |